



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 197

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 1 нэгж талбарын, 24490 м.кв талбайтай, 545,739,200.00 (таван зуун дөчин таван сая долоон зуун гучин есөн мянга хоёр зуун) төгрөгийн балансын үнэ бүхий газар эзэмших эрхээс 5062 м.кв талбай бүхий газар эзэмших эрхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуульд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн захирал С.Батмягмар, Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн захирал Э.Нүрзэд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3. Шилжүүлж буй газрыг шинэчлэн баталгаажуулж, бүртгэх, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132061354
11-r huraldaan.docx